



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Дотоод заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 5.3.1, 5.4.1, Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, засгийн үндэслэл хүлээн авах журмын 8.1 -ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн болон тодотгол тайланг хянахад баримтлах дотоод заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Ашигт малтмалын орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хянах, танилцах, санал дүгнэлт боловсруулах дотоод заавар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан дотоод зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Ашигт малтмалын хайгуулын хэлтэс (М.Энхжаргал), Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд), Нүүрс, судалгааны хэлтэс (М.Мэндбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч дарга (Б.Түвшинжаргал)-д даалгасугай.


ДАРГА



Л.БАЯРМАНДАЛ

5371 525

05.02.2022



АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН БОЛОН ТОДОТГОЛ ТАЙЛАНГ ХЯНАХАД БАРИМТЛАХ ДОТООД ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү дотоод зааврын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн ЭБМЗ-ийн дүрмийн 5.3.1-т заасан асуудлыг тухайн асуудал хариуцсан нэгж бусад нэгжийн албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу танилцах, хянах, санал, дүгнэлт гаргахад оршино.

Хоёр. Тайлантай танилцаж, хянах

2.1. Зохиогчоос ирүүлсэн ашигт малтмалын хайгуулын ажлын нөөцийн тооцоо, үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын тодотгол тайлан, нэмэлт хайгуулын ажлын тайлангийн бичвэр, хэвсрэлтуудыг Ашигт малтмалын хайгуулын асуудал хариуцсан нэгж нь хүлээн авч хяналтын хуудас нээнэ.

2.2. Тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн эсвэл дотоод журмын дагуу түүний ажлыг орлон ажиллаж буй мэргэжилтэн, уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн нөөцийн хөдөлгөөний мэргэжилтэн тус бүр ажлын 3 хоногт багтаан хянаж, тайлан зохиогчид зөвлөмж болгох, нөөцийн тооцоолол, техник, технологийн шийдэлтэй санал нийлэхгүй тохиолдолд Маягт 1-д заасан хяналтын хуудаст тэмдэглэнэ.

2.3. Тухайн асуудал хариуцсан нэгж нь хайгуулын ажлын нөөцийн тооцоо, үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын тодотгол тайлан, нэмэлт хайгуулын ажлын тайланг нөөцийн тооцоолол алдаатай, үлдэгдэл болон ашигласан нөөц зөрүүтэй тохиолдолд буцааж болно.

2.4. Ашигт малтмалын хайгуулын асуудал хариуцсан нэгжийн дарга нь хайгуулын ажлын тайланд өгсөн мэргэжилтнүүдийн саналтай танилцаж, дүгнэлт гарган хяналтын хуудсыг хааж, ЭБМЗ-ийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх эсхүл үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нэг удаа буцаах ба энэ тухай тайлан зохиогчид цахим захидал болон 77771900 утаснаас мессежээр мэдэгдэнэ.

Гурав. Тайлан архивд өгөх

3.1. Хариуцсан мэргэжилтэн нь ЭБМЗ-ийн тэмдэглэл, дүгнэлт, Нөөцийг бүртгэсэн тушаалыг хүлээн аваад хэлтсийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг оруулсны дараа тайланг архивд хүлээлгэн өгүүлэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Бусад

4.1. Холбогдох нэгжүүд энэхүү зааврыг дотооддоо мөрдөх бөгөөд зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой гомдол маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭГДЭХ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС № 22/.....

.....аймгийнсумын нутагт оршиххайгуулын/ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхийордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Шинжээч	Тайлан ирүүлсэн огноо	Хяналтын хуудас нээсэн огноо	Утасны дугаар
..... ХХК

№	Танилцсан	Тайлан материалтай танилцсан мэдээлэл /Танилцах, хянах асуудлууд 2.3/	Мэргэжилтэн хүлээн авсан огноо	Мэргэжилтэн хянаж дууссан огноо	Гарын үсэг
1	АМХХ-ийн дарга	-Тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн байдлыг холбогдох бусад нэгжүүдээс тодруулах, хаах, -Хайгуул, ашиглалтын ажлын тайлан төлөвлөгөөний цахим системээс тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн жилийн төлөвлөгөө тайлан ирүүлсэн эсэх, -Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулсан эсэх, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын гэрээ түүний үр дүнг тусгасан эсэх			
2	АМХХ-ийн мэргэжилтэн	-Тайланг хянаж буй хариуцсан мэргэжилтнүүд нь нүүр хуудас, огноо, гарын үсэг, гарчигийн дагуу бичигдсэн эсэх, хүснэгт, зураг, хавсралт зургийн бүрдэл зааврын дагуу эсэх, товч дүгнэлт, танилцуулга, бусад мэдээлэл -Ашигт малтмалын нөөцийн тооцоолол алдаатай, үлдэгдэл болон ашигласан нөөц зөрүүтэй тохиолдолд буцаах,			
3	Тухайн уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн нөөцийн хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн	-Хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох нөөцийн бүртгэл, хөдөлгөөний асуудал; Хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд өмнөх судалгааны ажлаар улсын нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн нөөцтэй давхцсан бол нөөцийн давхцалыг арилгах эсхүл талбайд гадна болон доторх хэсгийг хэмжилтээр салгах, олборлосон, үлдэгдэл нөөцийн талаар тодорхой болгох			

А/Б



**АШИГТ МАЛТМАЛЫН ОРД АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНИК,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ, ХЯНАХ, САНАЛ ДҮГНЭЛТ
БОЛОВСРУУЛАХ ДОТООД ЗААВАР**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү дотоод зааврын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх заалтын дагуу ирүүлсэн ЭБМЗ-ийн дүрмийн 4.4-т заасан асуудлыг төрийн захиргааны байгууллагын уул уурхайн асуудал хариуцсан нэгж /УУСХ, НСХ/-ийн албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу танилцах, хянах, санал дүгнэлт гаргахад оршино.

Хоёр. ТЭЗҮ-ийн хяналтын хуудас нээх

2.1. ТЭЗҮ хариуцсан мэргэжилтэн төсөл захиалагчийн даалгавраар эрх бүхий этгээдийн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргаж, зохих засварыг хийж албажуулсан ТЭЗҮ-ийг хүлээн авч хяналтын хуудас нээнэ. Хэрэв ТЭЗҮ, түүний хавсралтын бүрдэл дутуу, “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын 5.1 дэх хэсгийн 1-7 дугаар шаардлагуудын бүрдлийг хангаагүй тохиолдолд хяналтын хуудас нээхгүй.

Гурав. ТЭЗҮ-тэй танилцах, хянах, санал дүгнэлт гаргах

3.1. ТЭЗҮ-тэй танилцах мэргэжилтэн бүр нь тухайн орд, үйлдвэрийг ашиглах арга, аргачлал, техник технологийн шийдэл, эдийн засгийн судалгаа, шинжилгээний үндэслэл зэргийг холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байдлыг Маягт2-т заасан өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлыг тус бүр ажлын 2 өдөрт багтаан хянаж, санал дүгнэлт гаргана.

3.2. Нөөцийн хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн нь тухайн ТЭЗҮ-ийн геологийн болон үйлдвэрлэлийн нөөцтэй холбоотой асуудлаар засварт буцаах ба бусад асуудлаар санал, дүгнэлт боловсруулна.

3.3. Төсөл боловсруулагч энэхүү зааврын 3.2-т заасан засварыг хийхээс татгалзсан, эсхүл 3 дахиа алдаатай ирүүлсэн тохиолдолд ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хуралдаанд оруулахаас татгалзах саналыг нэгжийн даргад танилцуулж, нэгжийн дарга нь төсөл захиалагч, боловсруулагч, ЭБМЗ-ийн даргад цахим захидал болон 77771900 утаснаас мессежеер мэдэгдэнэ.

3.4. Нэгжийн дарга ажлын 2 өдөрт багтаан мэргэжилтнүүдийн гаргасан санал дүгнэлттэй танилцаж, санал дүгнэлтээ тусган хяналтын хуудсыг хааж, ЭБМЗ-ийн нарийн бичгийн даргад шилжүүлнэ.

3.5. Тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн эзгүй байх тохиолдолд ажил түр орлон гүйцэтгэх хуудаст ТЭЗҮ-тэй танилцах үүргийг тусгаж үлдээнэ.

3.6. ТЭЗҮ-тэй уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн танилцах нийт хугацаа нь ажлын 10 өдрөөс хэтрэхгүй байх бөгөөд төсөл боловсруулагчийн засвар хийх хугацаа үүнд ороогүй болно.

Дөрөв. ТЭЗҮ-ийг хүлээн авах тушаал гаргах, холбогдох статистик мэдээлэл авах

4.1. ТЭЗҮ хариуцсан мэргэжилтэн нь ЭБМЗ-ийн тэмдэглэл, дүгнэлтийг хүлээн аваад хэлтсийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг оруулсны дараа төсөл захиалагчаас ТЭЗҮ-ийг архивд хүлээлгэн өгсөн баримтыг үндэслэн ТЭЗҮ-ийг хүлээн авах шийдвэр гаргуулна.

Тав. Бусад

5.1. Холбогдох нэгжүүд энэхүү зааврыг дотооддоо мөрдөх бөгөөд зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой гомдол маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

--oOo--

Маягт 2.

ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС № 22/.....

.....аймгийн сумын нутагт оршихашиглалтын тусгай зөвшөөрөл бүхийордыг
 аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэл

Төсөл захиалагч	Төсөл боловсруулагч	Шинжээч	ТЭЗҮ ирүүлсэн огноо	Хяналтын хуудас нээсэн огноо	Жилийн хүчин чадал	Утасны дугаар
..... ХХК ХХК

№	Танилцсан	Журмын 5.1-т заасан шаардлага	Санал дүгнэлт	Хүлээн авсан огноо	Хүлээлгэн өгсөн огноо
1	Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	8. Геологийн судалгаа 9. Олборлолт 16. Тавигдах ерөнхий шаардлага - Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол			
2	Ашигт баяжуулалтын технологи, экспорт мэргэжилтэн малтмалын техник, бүтээгдэхүүн, хариуцсан	10. Баяжуулалт, боловсруулалт 11. Дэд бүтэц			

3	Уул уурхайн салбарын хүний нөөц, ХАБ, байгаль орчны судалгаа хариуцсан мэргэжилтэн	12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа эрсдэлийн менежмент 13. Байгаль орчин - Ажиллах хүчний жагсаалт			
4	Эдийн засгийн судалгаа хариуцсан мэргэжилтэн	14. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө 15. Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ - Төслийн хөрөнгө оруулалт, зардлын тооцоо			
5	Уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн дарга	- Хяналтын хуудсыг хаах			